



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.05.28 № 03/9356

танай _____-ны № _____-т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан МИАТ/20240102142 дугаартай “Орон нутгийн нислэгийн мэдээллийн технологийн тоног төхөөрөмж /Он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээ/” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын 1 дүгээр багцад оролцсон “Бэнкью тех” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Бэнкью тех” ХХК-ийн гомдолд тус компанийн тендерээс ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн байх туршлагын шаардлага хангаагүй гэж татгалзсан шийдвэрийг зөвшөөрөхгүй, захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Эйблсофт” ХХК-ийн тендерт санал болгосон 2 программ хангамжийн инженер шаардлага хангахгүй бөгөөд Л.Даваарагчаа программ хангамжийн инженер мэргэжилгүй байх тул хянан үзэхийг хүссэн байна.

I.Гомдолд дурдсан үндэслэлээр “Бэнкью тех” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: Шаардана. Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй үйлчилгээг сүүлийн 3 жилийн аль нэг жилд доод тал нь 1 удаа гүйцэтгэсэн байх” гэж, ТШЗ 19.2.4-т “Оролцогчийн туршлагыг харуулах заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 2, 3-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл ирүүлнэ. Мэдээллийг нотлох баримт бичиг ирүүлнэ. Үүнд: Ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хуулбар. Ижил төстэй ажилд “дүйцэхүйц” үйлчилгээ үзүүлсэн туршлагыг тооцно.” гэж, ТШЗ 2.1-д “Нийт төсөвт өртөг: 286,092,000.0 (хоёр зуун наян зургаан сая ерэн хоёр мянга) төгрөг” гэж тус тус заасан байна.

Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр “Бэнкью тех” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзэхэд тендерт “1_TenderiinMayagt.pdf”; 2_Sankhuugiin_chadavhi_ba_companiin_taniltsuulga.pdf”; 3_Technikiin_chadavhi.pdf”; 5_Tenderiin_batalгаа.pdf” гэх нэр бүхий 4 файл хавсаргасан байх ба тус бүрд ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл агуулагдаагүй байх тул тендерт 5

файл хавсаргасан, захиалагч тус компанийн илгээсэн ижил төстэй гэрээний мэдээллийг хянан үзээгүй гэх гомдол үндэслэлгүй байна.

II. Гомдолд дурдсан үндэслэлээр захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Эйблсофт” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: Шаардана. Үүнд: Хөгжүүлэгч - 2, программ хангамжийн мэргэжилтэй байх” гэж, ТШЗ 19.2-т “1. Шаардсан хүний нөөцийг мэдээллийг V бүлгийн маягтын дагуу ирүүлэх; 3. Санал болгож буй хүний нөөцийн анкетыг ирүүлнэ. /CV/” гэж тус тус заасан байна.

“Эйблсофт” ХХК-ийн тендерийн ирүүлсэн хүний нөөцийн мэдээлэлд хөгжүүлэгчээр Л. Даваарагчаа, Г. Мөнхболд нарыг санал болгосон байх ба Л. Даваарагчаагийн намтарт түүнийг Шинжлэх ухааны технологийн их сургууль (ШУТИС)-ийн Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургуулийг 2019 онд мэдээллийн системийн шинжээчээр төгссөн гэж ирүүлжээ.

Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээс “Эйблсофт” ХХК-ийн санал болгосон дээрх ажилтнуудын боловсролын дипломын лавлагааг татаж шалгахад Л. Даваарагчаа нь ШУТИС-ийг “Бизнесийн удирдлага”, Г. Мөнхболд “Мэдээллийн сүлжээ” мэргэжлээр тус тус төгссөн болохыг тодорхойлсон байхад дээрх шаардлага хангасан гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

Тендер шалгаруулалтын хувийн хэрэгт хавсаргасан үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд “Эйблсофт” ХХК-ийн тендерт санал болгосон программ хангамжийн инженер нь бизнесийн удирдлага мэргэжилтэй хэдий ч компанидаа программистаар ажиллаж байгаа, мөн “Оюу толгой” компанийн ажлыг гүйцэтгэсэн туршлагатай тул шаардлагад нийцнэ гэж үзсэн талаар дурджээ.

Захиалагчийн тогтоосон чадавхын болон туршлагын доод шаардлага буюу дээрх тендер шалгаруулалтын хувьд өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан үйлчилгээ үзүүлэх хүний нөөцөд тавигдсан мэргэжлийн шаардлага нь хуулийн 26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсэгт заасан “хуулийн 26.4.2, 26.4.3-т зааснаар хянан үзэхэд өрсөлдөөнд сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг харгалзан үзсэний үндсэн дээр хүлээн зөвшөөрөх зөрүү”-нд хамаарахгүй болохыг анхаарна уу.

Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 01/1219 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтад үндэслэн тендер шалгаруулалтын тендерийн үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Бэнкью тех” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ж. ГАНБАТ

